

## МОНГОЛ, ХЯТАДЫН ХАМТАРСАН МЭДЭГДЭЛ

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын дарга Ху Жинтаогийн урилгаар Монгол Улсын Ерөнхийлөгч Нацагийн Багабанди 2004 оны долдугаар сарын 1-6-нд БНХАУ-д төрийн айлчлал хийв.

Айлчлалын үеэр Ерөнхийлөгч Н.Багабанди, Улсын дарга Ху Жинтао нар хэлэлцээ хийв. БНХАУ-ын Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын Хорооны дарга У.Бангуо, Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Зябао, Улсын дэд дарга Зэн Чинхун нар Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид тус тус бараалхав. Хоёр улсын удирдагчид өөр өөрийн орны дотоод байдлын талаар харилцан мэдээлж, Монгол, Хятадын сайн хөршийн харилцан итгэсэн түншлэлийн харилцааг цаашид хөгжүүлэх болон олон улс, бүс нутгийн харилцан сонирхсон асуудлаар нухацтай санал солилцож, өргөн хүрээнд нэгдмэл ойлголтод хүрэв.

Хоёр улсын удирдагчид Монгол, Хятадын хооронд сайн хөршийн харилцан итгэсэн түншлэлийн харилцаа тогтож, хоёр улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа шинэ агуулга, хэлбэрээр баяжин амжилттай хөгжиж байгаад сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлэв. Монгол, Хятадын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээ болон хоёр талын улс төрийн бусад баримт бичгүүдийн үзэл санааны дагуу, энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчмын үндсэн дээр хамтын хүчин чармайлт гаргаж, хоёр орны сайн хөршийн харилцааг цаашид хэлбэрэлтгүй урагшуулан хөгжүүлэхээ талууд санал нэгтэй илэрхийлэв.

Талууд бие биеийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал болон тус тусын сонгон авсан хөгжлийн замыг харилцан хүндэтгэх, бие биеийн эсрэг чиглэсэн цэрэг, улс төрийн аливаа эвсэлд оролцохгүй, нөгөө талын төрийн бүрэн эрхт байдал, аюулгүй байдалд хохирол учруулах ямар нэгэн гэрээ хэлэлцээрийг гуравдагч оронтой байгуулахгүй гэдгээ дахин нотлов. Монгол Улсын цөмийн зэвсэггүй статус нь бүс нутгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд ашиг тустай гэж хоёр тал үзэв. Энэхүү статусыг баталгаажуулахад чиглэсэн Монгол Улсын хүч чармайлтыг Хятадын тал дэмжиж байгаагаа илэрхийлэв.

БНХАУ-тай найрсаг харилцаа, хамтын ажиллагаагаа бүх талаар хөгжүүлэх нь Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг мөн гэж Монголын тал нотлов. Монгол Улстай сайн хөршийн найрсаг харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагааг улам бэхжүүлэн

хөгжүүлэх нь БНХАУ-аас хөрш зэргэлдээ орнуудтайгаа хэрэгжүүлж буй гадаад бодлогын чухал бүрэлдэхүүн хэсэг мөн хэмээн Хятадын тал нотлов.

Дээд, өндөр хэмжээний харилцан айлчлал нь Хятад, Монголын харилцааг тогтвортой хөгжүүлэх, харилцан ойлголцлол, итгэлцлэлийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд хоёр орны удирдагчдын төрөл бүрийн шууд харилцааг цаашид үргэлжлүүлэхээ талууд тэмдэглэв.

Талууд улс төр, эдийн засаг, аюулгүй байдал зэрэг салбарт яриа хэлцээ, хамтын ажиллагааг бэхжүүлэх, хоёр орны харилцааны асуудлыг яриа хэлэлцээний замаар зохистой шийдвэрлэх, хоёр талын бүх салбарын солилцоо, хамтын ажиллагааг цаашид тогтвортой хөгжүүлэхээр тохиролцов.

БНХАУ-ын Засгийн газар бол Хятад улсыг төлөөлөх цорын ганц хууль ёсны Засгийн газар мөн, Тайвань бол Хятад улсын нутаг дэвсгэрийн салшгүй хэсэг бөгөөд Тайванийн асуудал нь Хятадын дотоод хэрэг мөн гэж үздэгээ Монголын тал дахин нотлов. Монголын тал Хятад улсын явуулж буй “энх тайвнаар нэгтгэх”, “нэг улс, хоёр систем”-ийн чиг бодлогыг дэмжиж, “Тайвань тусгаар тогтнох” гэгчийг дэмжихгүй гэдгээ илэрхийлэв.

Талууд хоёр орны БХЯ-дын хооронд батлан хамгаалах, аюулгүй байдлын асуудлаар анх удаа зөвлөлдөх уулзалт хийсэн нь ашигтай болсныг тэмдэглээд, цаашид ийм зөвлөлдөх уулзалтыг үргэлжлүүлэх нь хоёр улсын энэ салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх, цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэв.

Талууд хоёр орны өнөөгийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд ахиц гарч буйд сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлэв. Талууд хамтын хөгжлийн төлөө байгалийн баялгийг нээн ашиглах, дэд бүтцийн хөгжлийг гол чиглэл болгосон харилцан ашигтай хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэн гүнзгийрүүлэхээ илэрхийлэв. Талууд өмнө нь тохиролцсон болон эдүгээ хэлэлцэж байгаа хамтын ажиллагааны томоохон төслүүдийг эн тэргүүнд хэрэгжүүлнэ. Хоёр тал тус тусын аж ахуйн нэгжүүд харилцан хөрөнгө оруулалт хийж, хамтран ажиллахыг бодлогын хүрээнд дэмжиж, эрх зүйн үйлчилгээ үзүүлэх, зөвшөөрөл олгох журмыг хялбаршуулах зэрэг арга хэмжээг цаашид хэрэгжүүлнэ.

Талууд соёл, боловсрол, эрүүл мэнд, аялал жуулчлал, байгаль орчныг хамгаалах, биеийн тамир, шинжлэх ухаан-техник, цөлжилттэй тэмцэх зэрэг салбарт хамтын ажиллагаагаа улам идэвхижүүлж, олон нийт, залуучууд, хүүхдийн байгууллагуудын харилцаа, хүн солилцоог

өргөжүүлэхээр тохиролцов. Хоёр улсын оюутан солилцооны цар хүрээг цаашид улам өргөжүүлэхээр талууд тохиролцов. Талууд Хятадын соёлын өдрүүдийг Монголд зохиосон нь хоёр ард түмний найрамдлыг гүнзгийрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэнийг тэмдэглэж, Монголын соёлын өдрүүдийг 2005 онд Хятадад зохиохоор тохиролцов.

Монгол, Хятадын хилийн шугамыг хоёр дахь удаагаа хамтран шалгах ажил амжилттай явагдаж байгаад сэтгэл ханамжтай байгаагаа талууд илэрхийлж, Монгол, Хятадын хил нь энх тайван, найрамдал, хамтын ажиллагааны зурвас болохыг нотлов.

Айлчлалын үеэр талууд Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр, БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт буцалтгүй тусламж олгох тухай эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны тухай Хэлэлцээр, БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт үр тарианы буцалтгүй тусламж олгох тухай солилцоо захидал, Төлбөр, тооцооны тухай Монголбанк, Хятадын Ардын банкны хоорондын хэлэлцээрт тус тус гарын үсэг зурав.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилгоор Хятадын талаас төрөл бүрийн хэлбэрийн туслалцаа, дэмжлэг үзүүлж байгаад Монголын тал талархал илэрхийлэв.

Талууд НҮБ-ын Дүрмийн зорилго, зарчим, олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн эрх зүйн хэм хэмжээг дагаж мөрдөхөө нотлов. НҮБ нь бүрэн эрхт улсуудаас бүрдсэн дэлхий дахины хамгийн өргөн төлөөлөл, нэр хүнд бүхий засгийн газар хоорондын олон улсын байгууллага бөгөөд дэлхий нийтийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, олон улсын маргааныг шийдвэрлэх, эдийн засаг, нийгэм, байгаль орчин болон бусад салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд түүний гүйцэтгэж байгаа үүргийг талууд өндрөөр үнэлэв. НҮБ-ыг олон улсын шинэ нөхцөл байдалд нийцүүлэн өөрчлөн шинэтгэх үйл явцыг түргэтгэх, үүргийг нь цаашид улам бэхжүүлэх нь зүйтэй гэж талууд үзэв. Талууд НҮБ-ын хүрээнд хамтын ажиллагаагаа идэвхижүүлэхээр тохиролцов.

Хоёр тал олон улс, бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, бүс нутагт хамтын ажиллагаа хөгжүүлэх, итгэлцлийг бэхжүүлэх чиглэлээр хоёр болон олон талын хүрээнд гаргаж буй хүчин чармайлтаа цаашид улам бүр эрчимжүүлэхээр тохиролцов. Талууд бүс нутагт улс төрийн яриа хэлэлцээг өрнүүлэн хөгжүүлж, итгэлцлийг бэхжүүлэхэд тус тусын зүгээс гаргаж буй хүчин чармайлтыг дэмжиж байгаа бөгөөд Зүүн Хойд Азийн яриа хэлэлцээ, хамтын ажиллагааг

өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр хоёр талаас дэвшүүлсэн санал, санаачлагыг харилцан талархан хүлээн авав.

Талууд Солонгосын хойг цөмийн зэвсэгээс ангил байхыг дэмжиж, тус хойгийн цөмийн асуудлыг яриа хэлэлцээний замаар зохистой шийдвэрлэх, Солонгосын хойг, тус бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг сахин хамгаалах ёстойг онцлон тэмдэглэв.

Зургаан талт яриа хэлэлцээний үйл явцыг урагшлуулахын төлөө Хятадын тал болон холбогдох талуудын зүгээс гаргаж буй хүчин чармайлтыг Монголын тал өндрөөр үнэлэв.

Хоёр тал тус бүс нутагт байгуулагдсан төрөл бүрийн олон талын хамтын ажиллагааны байгууллагууд нь бүс нутгийн тогтвортой байдлыг хамгаалах, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд улам бүр чухал нөлөө үзүүлж байна гэж үзэв.

Монгол Улс Азийн хамтын ажиллагааны яриа хэлцээ (АХАЯХ)-д гишүүнээр элсч, ШХАБ-д ажиглагч болсонд Хятадын тал баяр хүргэв. Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа (АПЕК)-ны гишүүн болох, мөн Ази, Европын чуулга уулзалт (АСЕМ)-д нэгдэн орох Монгол Улсын эрмэлзлийг БНХАУ дэмжиж байгаагаа дахин нотлов.

Дамжин өнгөрөх тээврийн асуудлаар Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын хооронд явагдаж байгаа яриа хэлэлцээг эрх тэгш, харилцан ашигтай байх, найрсгаар хамтран ажиллах үндсэн дээр аль болох түргэн дуусгах нь гурван улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд түлхэц болно гэж талууд үзэв.

Олон улсын терроризм өнөөгийн дэлхий дахины энх тайван, хөгжилд учирч буй ноцтой аюул занал болж байна гэж талууд үзэв. Талууд терроризмын аливаа хэлбэрийг санал нэгтэй зэмлэн буруушааж, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар террорист үйлдлийн эсрэг тууштай тэмцэхийн төлөө байгаагаа илэрхийлэв.

Ерөнхийлөгч Н.Багабанди Хятадын тал халуун дотноор хүлээн авсанд талархал илэрхийлж, Монгол Улсын Их Хурлын дарга С.Төмөр-Очир, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр нараас Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооны дарга У.Бангуо, Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Зябао нарт илгээсэн халуун дотно мэндчилгээг уламжлав. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди БНХАУ-ын дарга Ху Жинтаог тааламжтай цагтаа Монгол Улсад айлчлахыг урив. Монгол Улсад айлчлахыг урьсанд Улсын дарга Ху Жинтао талархал илэрхийлэв.

2004.07.09